

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-34
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	35-66
<hr/>	
1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	35-56
2. Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	56-57
3. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	57-60
4. Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	60-64
5. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-65
6. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	65-66

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Ж.Эрдэнэбат.

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган, мөн аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ж.Ганболд, Булган аймгийн Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд, Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн багш, доктор Г.Жаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж өөрчилж, төслийн бусад зүйл, хэсэг, заалтын “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл нэмэх:

**“14 дүгээр зүйл.Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо,
мэдээллийн технологи ашиглах**

14.1.Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана:

14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

14.1.2.шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох;

14.1.3.дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндрокс орчинд туршиж, оршин суугчийн саналыг авах;

14.1.4.харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, мэдээллийн системийг бий болгох, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангах, саадгүй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

14.1.5.хотод цугларсан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон, олон нийтэд ил тод байршуулах.

14.2.Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндрокс орчныг бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална.

14.3.Хот, тосгон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн систем, түүний дэд бүтцийг ашиглана.

Тайлбар: Энэ зүйлд заасан “юмсын интернэт” гэж эд зүйлсийг цахим орчинд хянах, удирдах зорилгоор өгөгдлийг цуглуулж, дамжуулах зориулалт бүхий мэдрэгч болон бусад төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг хооронд нь холбосон сүлжээг ойлгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасан “зохицуулалтын сэндрокс орчин” гэж шинээр нэвтэрч байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчин, тодорхой цаг хугацаанд туршихыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар бүлгийн, мөн 14 дүгээр зүйлийн гарчгийн, 14.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Тосгоны Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба Зөвлөлийн гишүүний тоо 9 байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж нэмж, 15.3, 15.4 дэх хэсгийн “Зөвлөлийн” гэсний өмнөх “Хотын” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“15.3.Тосгоны зөвлөл энэ хуулийн 15.1.8 болон 15.1.4-т заасан албан татварын хувь хэмжээг тогтоохоос бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын Захирагч” гэсний дараа “, тосгоны Зөвлөлийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга, эсхүл орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 17.7 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн “Улсын зэрэглэлтэй хотын” гэснийг, 18.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 18.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.4,” гэснийг, “хотын” гэснийг тус тус хасаж, “шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэх ба 24.1.4-т заасан тохиолдолд огцорсонд тооцно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “томилно” гэснийг “томилж, чөлөөлнө.” гэж, 28.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.51 дэх заалтыг бүхэлд нь, 29.1.3 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан асуудлаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.45 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “, 30.1.4-д заасан тохиолдолд огцруулах” гэснийг, 30.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад” гэснийг хасаж, 30.3 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгон, хотын хорооны” гэж өөрчилж, 30.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 30.7 дахь хэсэг болгох:

“30.7.Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон тохиолдолд хот, тосгон, хотын хорооны захирагчийг огцорсонд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “хотын Захирагчийг дээд шатны Захирагч, Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд” гэснийг “улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг Ерөнхий сайд, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг харьяалах дээд шатны Захирагч, эсхүл Засаг дарга” гэж, 31.1.4 дэх заалтын “зохих ёсоор” гэснийг “удаа дараа” гэж өөрчилж, 31.1 дэх хэсгийг 30.4 дэх хэсэг болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.4, 31.1.5, 31.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг болгох:

“30.5.Хотын хорооны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө хотын захирагч энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.2, 33.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“33.2.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

33.3.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг” гэснийг “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг тухайн тосгоны оршин суугчдаас сонгож,” гэж, “томилно” гэснийг “батламжилна” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 34.5 дахь хэсэг нэмж, дугаарлалыг өөрчлөх:

“34.5.Тосгоны Захирагчийн үйл ажиллагааны зардлыг тухайн тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг болгох:

“30.6.Тосгоны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө тухайн тосгоны Зөвлөл энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.3, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг хасаж, 35.1.8 дахь заалтын “санал гаргах,” гэсний дараа “төлөвлөгөөг батлуулах” гэж нэмж, 35.1.2 дахь заалтын “шууд” гэснийг “ерөнхийлөн” гэж, 35.1.20 дахь заалтын “харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын” гэснийг “тосгоны” гэж, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.3 дахь хэсэг нэмэх:

“36.3.Хот, тосгоныг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “хот нь аймаг, нийслэлийн, тосгон нь аймгийн” гэснийг “хот болон тосгон нь аймаг, нийслэлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн гарчгийн “Чөлөөт бүс” гэсний дараа “, эдийн засгийн тусгай бүс” гэж нэмж, 40.1 дэх хэсгийн “чөлөөт бүстэй” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүстэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.3 дахь хэсэг нэмэх:

“40.3.Хотын эдийн засгийн тусгай бүстэй холбогдох харилцааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38-45 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтын “бохир ус,” гэсний дараа “цэвэрлэх байгууламж,” гэж нэмж, 41.3 дахь хэсгийн “сан байгуулах, түүнийг” гэснийг “сангийн хөрөнгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь заалтын “засаг захиргааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны–Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “тэдгээрийн” гэснийг “хотын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “барилга,” гэснийг “барилгын болон бусад” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн, мөн 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар” гэснийг “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж тус тус, 29 дүгээр зүйлийн 29.1.32 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.16 дахь заалтын “нийгэм хамгаалал, халамж, гэснийг “нийгмийн хамгаалал” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн, мөн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь

заалтын, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус, 17.8 дахь хэсгийн “хэлэлцүүлэхээр” гэснийг “хэлэлцүүлэх санал” гэж, 17.9 дэх хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 17.10 дахь хэсгийн “хуралдах тохиолдолд” гэснийг “хуралдахад” гэж, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн заалт” гэснийг “зүйл, хэсэг, заалт” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “заасны дагуу нэр дэвшигчдийн” гэснийг “заасан нууц санал хураалтаар нэр дэвшигчийн” гэж, 20.5 дахь хэсгийн “хүний” гэснийг “нэр дэвшигчийн” гэж, 20.6 дахь хэсгийн “хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн” гэснийг “хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “хуралд” гэснийг “хуралдаанд” гэж, 22.2.1 дэх заалтын “гомдлыг” гэснийг “гомдолд” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Хотыг өдөр тутамд удирдах” гэснийг “Хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.48 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.2 дахь заалтын “хот байгуулалтын” гэснийг “хотын” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.25 дахь заалтын “үйлчилгээг зохион байгуулж байгаад” гэснийг “үйлчилгээний зохион байгуулалтад” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.50 дахь заалтын “хот” гэснийг “хотын” гэж, 29.1.53 дахь заалтын “байгууллага” гэснийг “байгууллагын” гэж, “үүргээ хэрхэн биелүүлж байгаад” гэснийг “үүргийн биелэлтэд” гэж, 29.1.54 дэх заалтын “газарт” гэснийг “газрын хэмжээнд” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “Хотын” гэснийг “Хот, тосгон, хотын хорооны” гэж, 30.1 дэх хэсгийн “Захирагчийн бүрэн эрх” гэснийг “захирагчийг” гэж, “дуусгавар болно” гэснийг “чөлөөлнө” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “хэрэгцээний” гэснийг “хэрэглээний” гэж, 35.1.17 дахь заалтын, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хот” гэснийг “хотын” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “хүмүүст” гэснийг “хүнд” гэж, “хүмүүсийг” гэснийг “хүнийг” гэж өөрчилж, төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт болгон, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг болгон, 30 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон тус тус шилжүүлэх.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “хотод” гэснийг, 25 дугаар зүйлийн гарчгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтын “явуулж буй” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “асуудал санаачлан” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “оршин суугч” гэснийг, 33 дугаар зүйлийн гарчгийн “, бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох” гэснийг, 33.1.3 дахь заалтын “асуудлаар” гэсний дараах **“захиран зарцуулах” гэснийг**, 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалтын “болон” гэснийг, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “хот, тосгоны” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “хотын” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “гэрээний” гэсний өмнө “нийтийн эрх зүйн” гэж, 28 дугаар зүйлийн 28.6, 28.7 дахь хэсгийн “Захирагчийн” гэсний өмнө, 28.8 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “Хотын” гэж, 43 дугаар зүйлийн гарчгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “Захирагчийн” гэсний өмнө “хот, тосгоны” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэж, мөн заалтын “Төв аймгийн засаг дарга” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 10 дахь заалтын “Чингэлтэй хот, Сэлбэ хотын Зөвлөл” гэснийг “Чингэлтэй хотын Зөвлөл” гэж, мөн хүснэгтийн 14 дэх заалтын “Баян-Өлгийн аймгийн Засаг дарга” гэснийг “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 15 дахь заалтын “Баянхонгор аймгийн Засаг дарга” гэснийг “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Ганболд нарын гаргасан, Төслийн холбогдох заалтад “Хархорин орон нутгийн зэрэглэлтэй хот” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.2.11 дэх заалт:

“11.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.”

2/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“9.Аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлээс хэрэгжүүлж байгаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан үйл ажиллагааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрөөс чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“68.5.Энэ хуулийн 68.1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу хот, тосгонд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсгийн “Хотын зөвлөл” гэснийг “Хот, тосгоны зөвлөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3 дахь заалтын” гэснийг “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2,

24.3.3, 24.3.4, 24.5 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.2, 25.4.3 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 буюу 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хот, тосгоны эрх зүйн байдлын дагуу байгуулагдсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 буюу 77 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3/78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Төрийн болон орон нутгийн төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

11.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:

“7.4.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байршилд тухайн хотын газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны, тусламж, үйлчилгээ, спортын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварыг 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.”

7.5.Энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага, стандартыг Засгийн газар батална.

7.6.Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт хамрагдсан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.4 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн ““Байгалийн” гэсний өмнө”” гэснийг ““дараа сарын” гэсний өмнө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

13.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “23.10 дахь хэсгийн “аймаг” гэсний дараа “, хот” гэж” гэснийг “23.10 дахь хэсгийн “Аймаг,” гэсний дараа, “суманд оршин суудаг”, “сумын төв нь”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө “хот,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

14.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.22 дахь заалтын “хотын Зөвлөлийн дарга тухайн шатны Зөвлөлийн төсвийн” гэснийг “хот, тосгоны Захирагч тухайн шатны төсвийн” гэж, 4 дэх заалт буюу 23.14 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 14.1.23, 14.1.24 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4/23 дугаар зүйлийн 23.8.18 дахь заалт:

“23.8.18.хотын албан татвар.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“23.6.3.нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувь” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 9
Бүгд: 11
18.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“23.4.2.нэмэгдсэн өртгийн албан татварын 90 хувь” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 10
Бүгд: 11
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт, 61.1, 63.4, 64.1 дэх хэсэг дэх “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 8.5.4 дэх заалт дахь “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж,—29.3 дахь хэсэг дэх “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 57.4 дэх хэсэг дэх “орон нутгийн зэрэглэлтэй хот” гэснийг “болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэж тус тус өөрчилж, “16 дугаар зүйлийн” гэсний дараа “16.3 дахь хэсгийн” гэж нэмж, 42.3.3 дахь заалт, 66.1 дэх хэсэг дэх “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 56.3.2 дахь заалт дахь “хотын” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 19.5 дахь хэсэг, 4 дэх заалт буюу 36.1, 36.2, 36.6 дахь хэсэг, 9 дэх заалт буюу 61.4 дэх хэсэг, 10 дахь

заалт буюу 63.3 дахь хэсгийн “хотын” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 14 дэх заалт буюу 19.6.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж тус тус өөрчилж, 2 дахь заалт буюу 21.2, 21.3 дахь хэсэг, 15 дахь заалт буюу 67.2.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 6 дахь заалт буюу 58.1.1 дэх заалтын “хот,” гэсний дараа “тосгон” гэж, 12 дахь заалт буюу 67.3 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “хот, тосгоны” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 56.3 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийн “нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт, улсын зэрэглэлтэй хотын Захирагч нь орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт” гэж,” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 59.2 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “59.2 дахь хэсгийн “нийслэл” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хот” гэж, “дүүргийн” гэснийг “дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж,” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалт буюу 60.6 дахь хэсгийн “хот, улсын зэрэглэлтэй хотын хорооны” гэснийг “хотын” гэж, 9 дэх заалт буюу 61.3 дахь хэсгийн “Засаг дарга болон хот, тосгон, улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагч” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж, 12 дахь заалт буюу 67.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж тус тус өөрчилж, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг болон 13 дахь заалт буюу 8.5.1, 8.5.3 заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт дахь “Засаг дарга болон Захирагчаас” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчаас” гэж, 4.1.27, 8.9.3, 59.2.4 дэх заалт, 23.8, 23.9, 25.8, 39.1 дэх хэсэг дэх “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “8.8 дахь хэсгийн” гэсний өмнө “8.5.1, 8.5.3 дахь заалтын “Хуралд” гэснийг “Хурал болон Зөвлөлд” гэж,” гэж, “23.8, 23.9 дэх хэсгийн” гэсний өмнө “, 23.7.3 дахь заалт, 23.13 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн” гэснийг “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, “25 дугаар зүйлийн” гэсний өмнө “23.9.3 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, 24¹ дүгээр зүйлийн 24¹.1.1 дэх заалтын “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, 59.8 дахь хэсэг дэх “тосгоны” гэсний өмнө “орон нутгийн зэрэглэлтэй хот,” гэж, “66 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн гарчгийн “Хурлын” гэснийг “Хурал, Зөвлөлийн” гэж, 65 дугаар зүйлийн гарчгийн “даргын” гэснийг “дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн” гэж,” гэж, “66.1.3 дахь заалтын” гэсний өмнө “гарчгийн “даргын” гэснийг “дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн” гэж,” гэж тус тус нэмж, 36.3 дахь хэсэг дэх “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 66.1.6 дахь заалт дахь “хотын хороо,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

15.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.5.1 дэх заалтын “аймаг” гэсний дараа “, хот”” гэснийг “22.5.1 дэх заалтын “сумын төв нь”, “суманд байнгын”, “сумын нутаг дэвсгэр”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө болон “албан татварыг аймаг,” гэсний дараа “хот,”” гэж өөрчилж, мөн зүйлийн “28.6 дахь хэсгийн” гэсний дараа ““татвар нь”, “жилд” гэсний дараах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

16.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Засаг даргын” гэсний өмнө ““хооронд”, “дээд шатны” гэсний өмнөх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

19.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтын “Хурал” гэсний дараа “, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Энэ хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4, 35.1.5, 35.1.6, 35.1.7, 35.1.8, 35.1.9, 35.1.10, 35.1.11, 35.1.12, 35.1.13, 35.1.15, 35.1.16, 35.1.17, 35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн гарчиг болон 35.1 дэх хэсгийн “Засаг даргаас” гэснийг “Засаг дарга, хотын Захирагчаас” гэж, 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтын “олгоход”, “сунгахад” гэсний дараах “нийслэлд” гэснийг “нийслэл, нийслэлийн харьяа улсын зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “1 000 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “500 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх “аймгийн төвийн суманд” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “500 000 төгрөг”, “200 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “300 000 төгрөг”, “100 000 төгрөг” гэсний өмнөх “бусад суманд” гэснийг “суманд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

20.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн дугаарыг “40.8” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

21.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэсний дараа “хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэснийг “50 хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж,” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Хотын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төсөвт төвлөрүүлэх” гэсний өмнө “уг татварыг” гэж нэмэн, “харилцааг зохицуулна” гэснийг “харилцаанд үйлчилнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “тав тухтай амрах, зугаалах нөхцөлийг” гэснийг “байнгын болон улирлын үйл ажиллагаатай,

үйлчлүүлэгчийн тав тухтай амрах нөхцөлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “түүний дагалдах хэрэгсэл” гэснийг “тэдгээрийн дагалдах хэрэгсэл” гэж, 7.2.5 дахь заалтын “угаалгын үйлчилгээ” гэснийг “угаалгын газрын үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “ногдох албан татварыг” гэснийг “ногдуулсан албан татварыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

23.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 11, 13 дахь дэд заалтын “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр” гэснийг “Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 33 дахь дэд заалтын “Өвөрхангай аймгийн Арвайхээр сум” гэснийг “Өвөрхангай аймаг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 52 дахь дэд заалтын “Дархан хот” гэснийг “Дархан-Уул аймаг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 5 дахь заалтын “чиг үүргийг” гэсний өмнө “зарим” гэж тохиолдол бүр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмэх:

“6/Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зарим чиг үүргийг Шаргаморьт дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын зарим чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.

7/Нийслэлийн Багахангай дүүргийн чиг үүргийг Багахангай дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 10 дахь заалтын 1 дэх дэд заалтын “Нийслэл Улаанбаатар хотоос бусад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Ганболд нарын гаргасан, Төслийн холбогдох заалтад “Хархорин орон нутгийн зэрэглэлтэй хот” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

24.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан улсын их хуралд өргөн мэдүүлэх;

2/хот, тосгоны зөвлөл, захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Учрал танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл хэлэлцэх асуудлын дарааллын 4-т байгаа Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхийн өмнө хэлэлцэх горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдэн тул Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр тогтов./11.57/

Гурав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Ш.Адъяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа хариулж, тайлбар хийв.

Н.Энхболд: Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Г.Тэмүүлэн /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр нь” гэснийг “эдэлбэр газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “сонгон шалгаруулж, 4 жилийн хугацаагаар хотын Захирагч томилно” гэснийг “сонгоно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “(Цаашид ”Захирагчийн ажлын алба” гэх.)-” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,” гэсний дараа “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь хэсгийн “академи” гэснийг “үндэсний хүрээлэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт доор дурдсан 17.3.6 дахь заалт нэмэх:

“17.3.6.олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 18 дугаар зүйл нэмэх:

“18 дугаар зүйл.Олон улсын санхүүгийн төв

18.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан эдийн засгийн чөлөөт бүсэд тусгай дэглэм бүхий газар нутгийн хил зааг дотор олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн оролцогч байгууллагуудаас бүрдсэн олон улсын санхүүгийн төв байгуулна.

18.2.Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “16.1.1-д зааснаас бусад” гэснийг “16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан” гэж өөрчилж, “доор дурдсан салбарт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх хэсгийн “бэлгэдэл тэмдэг” гэснийг “бэлгэ тэмдэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “9.5-д” гэснийг “9.6-д” гэж, 11 дүгээр зүйлийн “хороонд” гэснийг “хороололд”, “хороо” гэснийг “хороолол” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “13.4.4” гэснийг “13.4.5” гэж, “13.4.5” гэснийг “13.4.6” гэж, “13.4.6” гэснийг “13.4.7” гэж, “13.4.7” гэснийг “13.4.8” гэж, “13.4.8” гэснийг “13.4.9”, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Шинэ Зуунмод хот /цаашид “хот” гэх/”, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци /цаашид “корпорац” гэх/” гэсэнтэй нийцүүлж тохиолдол бүрт өөрчлөх.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Нийслэл” гэсний дараа “хот” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд Шинэ Зуунмод хотын хотын хөгжлийн корпорац нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1-д заасан олон улсын санхүүгийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангана.

2.Төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Захирагчийн чиг үүргийг хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч хэрэгжүүлэх бөгөөд түүнийг нийслэлийн Засаг даргын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “38.1.22” гэснийг “38.1.23” гэж, “40.8” гэснийг “40.9” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн үндэслэх хэсгийн “тус тус” гэсний өмнө “, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг” гэж нэмэх.

2.Тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбилцол, талбайн хэмжээ, байршил” хүснэгтийн Төв аймгийн Сэргэлэн сумын “Шинэ Зуунмод /Төрийн захиргааны нэгдсэн цогцолбор/”-ын 1000 га газрын солбилцлыг тэгш өнцөгтийн солбилцлоор хийсэн байгааг газар зүйн солбилцол болгон нийцүүлж доор дурдсанаар өөрчлөх:

Төв аймаг, Сэргэлэн сум	3796 46.9	Шинэ Зуунмод хот (Төр, захиргааны нэгдсэн цогцолбор)	1000.0	1	106° 54' 21.302" E	47° 44' 55.904" N
				2	106° 56' 48.435" E	47° 45' 38.816" N
				3	106° 57' 48.615" E	47° 44' 37.151" N
				4	106° 58' 16.594" E	47° 44' 33.854" N
				5	106° 58' 21.284" E	47° 44' 20.591" N
				6	106° 57' 28.373" E	47° 43' 27.071" N
				7	106° 56' 55.500" E	47° 43' 39.500" N
				8	106° 56' 2.300" E	47° 43' 42.100" N
				9	106° 55' 58.497" E	47° 44' 11.712" N

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Г.Ганболд танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 08 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн *ирцтэйгээр* 12 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 10 цаг 21 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн учраас 2024 оны 5 сарын 24-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүдээ танилцуулах ёстой. Ирц хаана байна. Адьясүрэн гишүүн, Ганболд гишүүн, Мөнхцэцэг гишүүн, Амарсайхан гишүүн, Оюунчимэг гишүүн, Доржханд ирээгүй байна. Тогтохсүрэн гишүүн, Жаргалмаа гишүүн, Энхболд, Пүрэвдорж гишүүн, Сарангэрэл гишүүн нар ирсэн байна. Ингээд ирц бүрдлээ.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Түүрүүн бид нар санал хурааж байгаад орхисон.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл мөн хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна.

Одоо хуулиудаа бид нар төслүүдийг нь зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцэх ёстой. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйл дээр ирээд зогссон. Одоо үргэлжлүүлээд явна.

Ажлын хэсгийнхнийг оруулчихъя. Ажлын хэсгийн хэсгийнхнийг оруулаарай. Өнөөдөр Нийслэл, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны албаны хүмүүс, Удирдлагын академиас хүмүүс оролцож байгаа. Түүрүүн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг зарласан. Дээр нь бас манай өнөөдрийн хуралдаанд Сэлэнгэ аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ганболд. Босоод харуулчих. Булган аймгийн Хялгант тосгоны захирагч Сод-Эрдэнэ нар бас өнөөдрийн манай хуралдаанд оролцож байгааг танилцуулъя.

Асуудалдаа орцгооё.

11 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа.

Төслийн 11 дүгээр зүйлийн “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж өөрчилж, төслийн бусад зүйл, хэсэг, заалтын “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Ганболд гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Адьясүрэн гишүүн санал өгөх хүмүүсийн тоо хангалттай бүрдчихсэн үед гараараа хурааж болно. Горимын санал гаргаад. Дутуу байхад бас зохисгүй. Адьясүрэн гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Ганболд гишүүн өнөөдөр 2,3 Байнгын хороо давхардаж

яваад гишүүд бас 2, 3 талд санал өгөөд орж гараад байх шиг байна. Адяасүрэн гишүүн бүртгэлдээ орчихсон байна. Ганболд гишүүн, Тогтохсүрэн гишүүн нар хуралдаандаа ирье. Пүрэвдорж гишүүн бүртгэлдээ орчихсон байж байгаа. Санал хураах гээд байна. Ганболд гишүүн орж ирлээ. 11 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулсан. Санал хураалт. 6 гишүүн 60 хувийн саналаар дэмжлээ.

12 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

13 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

14 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирсэн. Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл нэмэх:

“14 дүгээр зүйл.Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо,

мэдээллийн технологи ашиглах

14.1.Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана:

14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

14.1.2.шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох;

14.1.3.дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндрокс орчинд туршиж, оршин суугчийн саналыг авах;

14.1.4.харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд

бүтэц, мэдээллийн системийг бий болгох, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангах, саадгүй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

14.1.5.хотод

цугларсан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон, олон нийтэд ил тод байршуулах.

14.2.Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндрокс орчныг бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална.

14.3.Хот, тосгон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн систем, түүний дэд бүтцийг ашиглана.

Тайлбар: Энэ зүйлд заасан “юмсын интернэт” гэж эд зүйлсийг цахим орчинд хянах, удирдах зорилгоор өгөгдлийг цуглуулж, дамжуулах зориулалт бүхий мэдрэгч болон бусад төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг хооронд нь холбосон сүлжээг ойлгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасан “зохицуулалтын сэндрокс орчин” гэж шинээр нэвтэрч байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчин, тодорхой цаг хугацаанд туршихыг ойлгоно.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн 63,6 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар бүлгийн, мөн 14 дүгээр зүйлийн гарчгийн, 14.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Тосгоны Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба Зөвлөлийн

гишүүний тоо 9 байна.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн 72,7 хувиар санал дэмжигдлээ. 14 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

15 дугаар зүйл дээр ирсэн ажлын хэсгийн саналуудыг танилцуулъя.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж нэмж, 15.3, 15.4 дэх хэсгийн “Зөвлөлийн” гэсний өмнөх “Хотын” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“15.3.Тосгоны зөвлөл энэ хуулийн 15.1.8 болон 15.1.4-т заасан албан татварын хувь хэмжээг тогтоохоос бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8-ыг нь урьд нь бичиж, 4-ийг нь хойно бичдэг нь ямар учиртай юм бол доо.

9 гишүүн 81,8 хувиар санал дэмжигдэж байна.

11.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын Захирагч” гэсний дараа “, тосгоны Зөвлөлийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга, эсхүл орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн 72,7 хувиар саналыг дэмжлээ.

16 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

17 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 17.7 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн, 72,7 хувиар дэмжлээ.

Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн “Улсын зэрэглэлтэй хотын” гэснийг,

18.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 18.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

Энийг түрүүн бид нар ингэсэн юм Тогтохсүрэн дарга аа. Энэ бас цаг аваад байх юм. Заримдаа ингээд 10, 10 секунд яваад. Энэ саналыг 8 гишүүн 72.7 хувиар дэмжлээ.

Тэгээд цаг хэмнэх үүднээс гараа өргөөд явчихъя гэсэн юм. Тэгвэл цаг хурдан болох юм байна. Одоо болбол хангалттай гишүүд ээ. Тийм учраас горимын санал гаргаж байна. Гараа өргөөд саналаа хураагаад явчихъя дэмжих үү. Мөнх-Оргил оо. Гараад явчихвал энэ дэглэм өөрчлөгдөөд явчихна.

Төслийн 19 дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Тоолоод хэлээд байгаарай. Чи босоод тоол Баттогтохоо. 11-ээс 9 гишүүн дэмжлээ.

Төслийн 21 дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй.

22 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

23 дээр санал, асуулт алга байна.

24 дүгээр зүйл дээр. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.4,” гэснийг, “хотын” гэснийг тус тус хасаж, “шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэх ба 24.1.4-т заасан тохиолдолд огцорсонд тооцно” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 9. Үгүй ээ, тэгэхээр болдоггүй юм аа. Тэгэхээр түрүүн түрүүн тэрнээс чинь болоод хурал тарчихсан юм. Тэр хүмүүс суугаад.

Байхгүй хойгуур дэмжлээ гэж хэллээ гээд асуудал гараад байхад.

Төслийн 25 дугаар зүйл дээр санал байхгүй.

26 дээр алга байна.

27 дээр алга байна.

28 дугаар зүйл дээр. Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “томилно” гэснийг “томилж, чөлөөлнө.” гэж, 28.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Гараа өргөхгүй бол тоолохгүй шүү. 11-ээс 7. Тэнд өргөхгүй байна.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.51 дэх заалтыг бүхэлд нь, 29.1.3 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан асуудлаар” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 9.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.45 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 9.

Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “, 30.1.4-д заасан тохиолдолд огцруулах” гэснийг, 30.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад” гэснийг хасаж, 30.3 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгон, хотын хорооны” гэж өөрчилж, 30.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 30.7 дахь хэсэг болгох:

“30.7.Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон тохиолдолд хот, тосгон, хотын хорооны захирагчийг огцорсонд тооцно.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-9.

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “хотын Захирагчийг дээд шатны

Захирагч, Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд” гэснийг “улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг Ерөнхий сайд, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг харьяалах дээд шатны Захирагч, эсхүл Засаг дарга” гэж, 31.1.4 дэх заалтын “зохих ёсоор” гэснийг “удаа дараа” гэж өөрчилж, 31.1 дэх хэсгийг 30.4 дэх хэсэг болгон шилжүүлэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 9 дэмжлээ.

Төслийн 32 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

Төслийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг болгох:

“30.5.Хотын хорооны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө хотын захирагч энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.2, 33.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“33.2.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

33.3.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8.

Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг” гэснийг “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг тухайн тосгоны оршин суугчдаас сонгож,” гэж, “томилно” гэснийг “батламжилна” гэж

өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 11-ээс 7.

Төсөлд доор дурдсан агуулгатай 34.5 дахь хэсэг нэмж, дугаарлалыг өөрчлөх:

“34.5.Тосгоны Захирагчийн үйл ажиллагааны зардлыг тухайн тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 9 дэмжлээ.

Төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг болгох:

“30.6.Тосгоны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө тухайн тосгоны Зөвлөл энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.3, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Санал хураалт. Огцруулахгүй гэж байгаа юм байна. Энэ санал дэмжигдээгүй шүү.

Тэгээд үндэслэлүүдийг нь заачихсан байна шүү дээ. Тэр тэр үндэслэлээр гэж. Саяынхыг дахиж хураах уу. Дахиж хураая. Саяын саналыг хүчингүйд тооцох санал хураая. Хүчингүй болгож байгаад. Дахиад санал хураая. Дахиад уншаадахъя. Анхааралтай хандаарай. Түүрүүн саналыг уншчихсан. Үгээ хэлчих. Ганболд гишүүний микрофон өгөөрэй.

Г.Ганболд: Үгүй ээ, энэ 31 тээ. Бичинь 31 дээр л юм ярих гээд байсан юм.

Н.Энхболд: Тэгвэл саяын 34 дэх хэсгийн 30.6-г томъёолсон ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ. 11-ээс дэмжигдээж байна.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг хасаж, 35.1.8 дахь заалтын “санал гаргах,” гэсний дараа

“төлөвлөгөөг батлуулах” гэж нэмж, 35.1.2 дахь заалтын “шууд” гэснийг “ерөнхийлөн” гэж, 35.1.20 дахь заалтын “харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын” гэснийг “тосгоны” гэж, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ. Гараа өргө л дөө тэгээд.

Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.3 дахь хэсэг нэмэх:

“36.3.Хот, тосгоныг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.” Санал хураалт. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 11-ээс 9 дэмжлээ.

Төслийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “хот нь аймаг, нийслэлийн, тосгон нь аймгийн” гэснийг “хот болон тосгон нь аймаг, нийслэлийн” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 9 гишүүн дэмжлээ.

Төслийн 38 дээр санал, асуулт алга байна.

Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал хураалт. Энэ юмнуудыг ер нь нэгтгэчихмээр юм байна даа бүх газрыг. 9 дэмжлээ.

Төслийн 40 дүгээр зүйлийн гарчгийн “Чөлөөт бүс” гэсний дараа “, эдийн засгийн тусгай бүс” гэж нэмж, 40.1 дэх хэсгийн “чөлөөт бүстэй” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүстэй” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 9 гишүүн дэмжлээ.

Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.3 дахь хэсэг нэмэх:

“40.3.Хотын эдийн засгийн тусгай бүстэй холбогдох харилцааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38-45 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 9.

Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтын “бохир ус,” гэсний дараа “цэвэрлэх байгууламж,” гэж нэмж, 41.3 дахь хэсгийн “сан байгуулах, түүнийг” гэснийг “сангийн хөрөнгийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11-ээс 8.

Төслийн 42 дээр асуулт, санал алга байна.

43 дээр асуулт, санал байхгүй.

44 дээр асуулт, санал алга.

45 дээр асуулт, санал алга.

Төслийн 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь заалтын “засаг захиргааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ. 11-ээс 8.

47 дээр санал, асуулт байхгүй байна.

48 дээр санал, асуулт алга.

49 дээр санал, асуулт алга.

Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж өөрчлөх. Ажлын хэсэг.

Санал хураалт. Байгааг нь л тоол 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 51 дүгээр зүйл дээр санал, асуулт алга байна.

Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ.

53 дээр санал, асуулт байхгүй.

54 дээр санал, асуулт байхгүй. Зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 9 дэмжлээ.

Найруулгын саналууд.

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “тэдгээрийн” гэснийг “хотын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “барилга,” гэснийг “барилгын болон бусад” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн, мөн 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар” гэснийг “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж тус тус, 29 дүгээр зүйлийн 29.1.32 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.16 дахь заалтын “нийгэм хамгаалал, халамж, гэснийг “нийгмийн хамгаалал” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн, мөн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтын, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус,

17.8 дахь хэсгийн “хэлэлцүүлэхээр” гэснийг “хэлэлцүүлэх санал” гэж, 17.9 дэх хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 17.10 дахь хэсгийн “хуралдах тохиолдолд” гэснийг “хуралдахад” гэж, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн заалт” гэснийг “зүйл, хэсэг, заалт” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “заасны дагуу нэр дэвшигчдийн” гэснийг “заасан нууц санал хураалтаар нэр дэвшигчийн” гэж, 20.5 дахь хэсгийн “хүний” гэснийг “нэр дэвшигчийн” гэж, 20.6 дахь хэсгийн “хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн” гэснийг “хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “хуралд” гэснийг “хуралдаанд” гэж, 22.2.1 дэх заалтын “гомдлыг” гэснийг “гомдолд” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Хотыг өдөр тутамд удирдах” гэснийг “Хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.48 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.2 дахь заалтын “хот байгуулалтын” гэснийг “хотын” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.25 дахь заалтын “үйлчилгээг зохион байгуулж байгаад” гэснийг “үйлчилгээний зохион байгуулалтад” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.50 дахь заалтын “хот” гэснийг “хотын” гэж, 29.1.53 дахь заалтын “байгууллага” гэснийг “байгууллагын” гэж, “үүргээ хэрхэн биелүүлж байгаад” гэснийг “үүргийн биелэлтэд” гэж, 29.1.54 дэх заалтын “газарт” гэснийг “газрын хэмжээнд” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “Хотын” гэснийг “Хот, тосгон, хотын хорооны” гэж, 30.1 дэх хэсгийн “Захирагчийн бүрэн эрх” гэснийг “захирагчийг” гэж, “дуусгавар болно” гэснийг “чөлөөлнө” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “хэрэгцээний” гэснийг “хэрэглээний” гэж, 35.1.17 дахь заалтын, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хот” гэснийг “хотын” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “хүмүүст” гэснийг “хүнд” гэж, “хүмүүсийг” гэснийг

“хүнийг” гэж өөрчилж, төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт болгон, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг болгон, 30 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон тус тус шилжүүлэх.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “хотод” гэснийг, 25 дугаар зүйлийн гарчгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтын “явуулж буй” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “асуудал санаачлан” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “оршин суугч” гэснийг, 33 дугаар зүйлийн гарчгийн “, бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох” гэснийг, 33.1.3 дахь заалтын “асуудлаар” гэсний дараах **“захиран зарцуулах”** гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалтын “болон” гэснийг, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “хот, тосгоны” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “хотын” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “гэрээний” гэсний өмнө “нийтийн эрх зүйн” гэж, 28 дугаар зүйлийн 28.6, 28.7 дахь хэсгийн “Захирагчийн” гэсний өмнө, 28.8 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “Хотын” гэж, 43 дугаар зүйлийн гарчгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “Захирагчийн” гэсний өмнө “хот, тосгоны” гэж нэмэх гэсэн найруулгын саналуудыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 8 гишүүн дэмжлээ.

Ганболд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 31.1.4, 31.1.5, 31.1.6 дахь заалтыг хасах. Энэ заалтуудыг нь уншаад өгчих. Наад дээрээс 31.1.4 нь юу

гэж байна. 31.1.5 нь юу гэж байна. 31.1.6 нь юу гэж байна.

31.1.4.татварын орлого бүрдүүлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй;

31.1.5.хотын захирагчийн хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх, түүнд хяналт тавих талаар дээд шатын захирагч Засаг даргаас өгсөн үүргийг биелүүлээгүй;

31.1.6 хотын захирагчийг сонгуулийн эрх бүхий оршин суугчийн 30-аас доошгүй хувь нь үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж огцруулах санал гаргасан бол гэсэн ийм 3 заалтыг хасъя гэсэн санал гаргаж байгаа юм байна. Анхааралтай сонссон биз. Ганболд гишүүний зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 7 дэмжлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулиудаар санал хураалт явуулна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай 1 дүгээр зүйл дээр асуулттай гишүүн байна уу. Алга байна. 2 дээр алга байна. 3 дээр алга байна.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох хуулийг төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр санал хураалт явуулна. Хэдэн зүйлтэй билээ энэ чинь. 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “Төв аймгийн

иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэж, мөн заалтын “Төв аймгийн засаг дарга” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 10 дахь заалтын “Чингэлтэй хот, Сэлбэ хотын Зөвлөл” гэснийг “Чингэлтэй хотын Зөвлөл” гэж, мөн хүснэгтийн 14 дэх заалтын “Баян-Өлгийн аймгийн Засаг дарга” гэснийг “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 15 дахь заалтын “Баянхонгор аймгийн Засаг дарга” гэснийг “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8.

2 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

3 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

4 дүгээр зүйл дээр санал, асуулт алга байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай.

Хуулийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.2.11 дэх заалт:

“11.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ

байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.”

2/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“9.Аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлээс хэрэгжүүлж байгаа Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан үйл ажиллагааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрөөс чөлөөлнө.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 7 дэмжлээ.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дээр байхгүй юм байна. Байхгүй санал, асуулт алга. 2 дээр санал, асуулт алга байна.

Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна. 2 дээр асуулт, санал алга.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

Хуулийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсэг ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“68.5.Энэ хуулийн 68.1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу хот, тосгонд шилжүүлнэ.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсгийн “Хотын зөвлөл” гэснийг “Хот, тосгоны зөвлөл” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжиж санал дэмжигдэж байна. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

2 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

3 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

Мөн хуулийн 4 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна.

Монгол Улс Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

Хуулийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулт алга байна.

2 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3 дахь заалтын” гэснийг “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3, 24.3.4, 24.5 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.2, 25.4.3 дахь заалтын” гэж өөрчлөх. Ажлын хэсгийг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжиж байна.

4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн алга байна.

5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цаг жоохон хэмнэх гээд Пүүжээ гишүүн ээ гараараа явчихсан юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай.

Хуулийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 буюу 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хот, тосгоны эрх зүйн байдлын дагуу байгуулагдсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсгийн санал. Дэмжье. 8 гишүүн дэмжлээ.

Мөн өслийн 1 дүгээр зүйлийн 2 буюу 77 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжсийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжсийн өөрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийг

тухайн хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлнэ.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7. Гараа өргөөрэй гишүүд ээ. Дэмжиж байгаа нь. Өргөөгүйг нь дэмжихгүйд тооцно шүү дэмжээгүйд. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Бас дахиад нэг санал байгаа юм байна 1 дүгээр зүйл дээр.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3/78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжсийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжсийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлнэ. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ. 8 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна.

3 дээр санал, асуулт алга байна.

4 дээр санал, асуулт байхгүй байна.

5 дээр санал, асуулт алга байна.

Нийслэлийн тухай хууль явж байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Сүүлийн 2, 3 санал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслүүдийн талаар явсан байна шүү. Нэг гарчгийн дээр уншихаж.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулж дууслаа.

Одоо Төрийн болон орон нутгийн төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр Тэмүүлэн гишүүнээс санал ирсэн байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал байна. Ажлын хэсэг энэ дээр санал нэгдэж байгаа юм уу. Учрал дарга аа. Санал хураалт Тэмүүлэн гишүүнийхээр. Энэ чинь тэгээд нөгөө хот тосгон юмнууд чинь өөрсдөө. Саяын унисан томьёолол. 2 заалттай л юм байна. Харчих хоёрхон заалттай юм уу. Хасъя гэж байгаа хууль маань ийм 2 заалттай.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2, 77 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх гээд хот, тосгоны эрх зүйн байдлын дагуу байгуулагдсан хот, тосгоны өмчийн харилцаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу байгуулагдсан тосгоны хувьд хот, тосгоны өмчийн зүйлсийг оршин суугчдаа төлөөлөн өмчлөх өмчлөгч нь хотын зөвлөл, тосгоны захирагч байна гэсэн. Тийм байна. Энэ ингэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн “бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн” гэснийг “болон нийслэл хотын аж ахуй, инжэнер хангамжийн бараа, ажил үйлчилгээг тухайн салбарын төрийн

болон орон нутгийн” гэж өөрчилсүгэй гэсэн заалт байгаа юм байна.

Сарангэрэл гишүүний микрофоныг өгье.

Д.Сарангэрэл: Энэ бид нарын одоо энэ ярьж байгаа заалт бол Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн бас гол цөм нь байгаад байгаа юм. Нийслэлд тулгамдаж байгаа асуудлуудыг тендерийн хуулийн хүрээнээс халихгүйгээр шуурхай хийж зохион байгуулах тухай л заалт байхгүй юу. Тийм болохоор бид нар бол энэ хуулийн заалтыг бол дэмжих ёстой гэсэн ийм саналтай байна.

Н.Энхболд: Санал хураалт явуулъя. Тэмүүлэн гишүүний саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 1 гишүүн. Тэмүүлэн гишүүний санал дэмжигдсэнгүй.

Тийм учраас 1 дүгээр зүйл дээр өөр байхгүй. 2 дугаар зүйл дээр алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна.

2 дугаар зүйл дээр алга байна.

3 дугаар зүйл дээр алга байна.

4 дүгээр зүйл дээр алга байна.

5 дугаар зүйл дээр алга байна.

Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр алга байна.

Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал. Энэ хэддүгээр зүйл дээр юм.

1 дүгээр зүйл дээр Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд 1 санал ирүүлсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн тухайн хотод гэснийг тухайн шүүхэд гэж өөрчлөх санал гаргасан Их хурлын гишүүн Цогтбаатар. Дэмжье. Санал хураалт. Ганболд гишүүн, Мөнх-Оргил гишүүн. 11-ээс 6. Энэ чинь хотод гэснийг нь л шүүхд нь гэж өөрчилсөн юм байна л даа. Энэ санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

2 дээр саналтай гишүүн алга байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Ажлын хэсгийн санал. Хууль санаачлагчид нь буцаах. Дэмжих санал хураалт. 6 гишүүн дэмжлээ. Энэ хууль буцлаа.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хууль санаачлагчид нь буцаах ажлын хэсгийн

саналыг дэмжье. Санал хураалт. 6 дэмжлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хууль санаачлагчид нь буцаах ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Ганболд, Жаргалмаа. 6 дэмжлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна.

2 дугаар зүйл дээр асуулт, санал. Энэ чинь юу нь ямар заалтууд байгаа билээ. Алга байна.

3 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр алга байна. 2 дугаар зүйл дээр асуулт, санал хаана байна. Энэ дээр чинь юм алга байна шүү дээ.

Төслийн 1 дүгээр зүйл дээр санал ажлын хэсгээс ирүүлсэн.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал. Энэ зөв байх. Санал хураалт. 6 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуулийн төсөл

1 дүгээр зүйл дээр санал байхгүй.

2 дугаар зүйл дээр Ажлын хэсгээс саналтай.

Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье. 6 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр санал байхгүй.

3 дээр байхгүй.

4 дээр байхгүй.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зүйл бүрээр нь хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр санал, асуулт алга байна.

2 дээр алга байна.

3 дугаар зүйл дээр алга байна.

4 дүгээр зүйл дээр алга байна.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:

“7.4.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байршилд тухайн хотын газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны, тусламж, үйлчилгээ, спортын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварыг 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.”

7.5.Энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага, стандартыг Засгийн газар батална.

7.6.Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт хамрагдсан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.4 дэх заалт хамаарахгүй.” гэж ажлын хэсгээс санал гаргасан байна. Асуулт байна уу. Байхгүй бол санал хураалт явуулъя. Энэ чинь нөгөө татвараас чөлөөлөх юмнуудтай бусад хуулиудтайгаа хэр нийцэж байгаа юм. 5 жил чөлөөлөх.

Аймгийн төвүүд орох уу. Сумууд бүгд орох уу. Татварын ерөнхий хуультайгаа зөрчилдөхгүй юу. Олон улсын стандартад нийцсэн юмнууд байх юм байна л даа. Сангийн яамтай тохирсон бол хамаагүй. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжье. 6. Ганболд гишүүнийг дэмжсэн гээд явлаа шүү. 7.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй байна.

3 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

4 дээр асуулт, санал алга байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байгалийн нөөц ашигласан төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн ““Байгалийн” гэсний өмнө”” гэснийг ““дараа сарын” гэсний өмнө” гэж өөрчлөх. Санал хураалт. 6 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

3 дээр асуулт, санал алга байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “23.10 дахь хэсгийн “аймаг” гэсний дараа “, хот” гэж” гэснийг “23.10 дахь хэсгийн “Аймаг,” гэсний дараа, “суманд оршин суудаг”, “сумын төв нь”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө “хот,” гэж” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Санал хураалт. 6 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.22 дахь заалтын “хотын Зөвлөлийн дарга тухайн шатны Зөвлөлийн төсвийн” гэснийг “хот, тосгоны Захирагч тухайн шатны төсвийн” гэж, 4 дэх заалт буюу 23.14 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 14.1.23, 14.1.24 дэх заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 6 гишүүн дэмжлээ.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4/23 дугаар зүйлийн 23.8.18 дахь заалт:

“23.8.18.хотын албан татвар.”” Санал хураалт. 7 Гишүүн дэмжлээ.

Бат-Амгалан гишүүнээс зарчмын зөрүүтэй санал ирсэн байна. 1 дүгээр зүйл дээр.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“23.6.3.нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувь” гэж нэмэхээр. Энэ дээр ажлын хэсэг юу гэж байгаа юм. Дэмжихгүй байгаа. Засгийн газар, Сангийн яам дэмжээгүй санал байна. Санал хураалт явуулъя. 11-ээс 2. Энэ санал дэмжигдсэнгүй.

2 дугаар зүйл дээр санал байхгүй.

3 дугаар зүйл дээр “23.4.2.нэмэгдсэн өртгийн албан татварын 90 хувь” гэсэн бас саяынх шиг санал байна. Засаг дэмжээгүй, ажлын хэсэг дэмжээгүй санал байна. Санал хураалт. 1 гишүүн дэмжсэн байна.

2 дугаар зүйл дээр саналууд байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт, 61.1, 63.4, 64.1 дэх хэсэг дэх “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж,..

энэ юмнуудыг бүгдийг нь нэг бичиж болоогүй л юм байх даа. Зарим нь зарчмын зөрүүтэй, зарим нь найруулгын шинжтэй юманд орчихсон байх юм.

...8.5.4 дэх заалт дахь “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж,... энэ бол болж байна.

...29.3 дахь хэсэг дэх “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 57.4 дэх хэсэг дэх “орон нутгийн зэрэглэлтэй хот” гэснийг “болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэж тус тус өөрчилж, “16 дугаар зүйлийн” гэсний дараа “16.3 дахь хэсгийн” гэж нэмж, 42.3.3 дахь заалт, 66.1 дэх хэсэг дэх “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 56.3.2 дахь заалт дахь “хотын” гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн

саналыг дэмжье. Санал хураалт гишүүд ээ. 7 дэмжлээ.

2 дугаар зүйлээр санал хураалт дууслаа.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 19.5 дахь хэсэг, 4 дэх заалт буюу 36.1, 36.2, 36.6 дахь хэсэг, 9 дэх заалт буюу 61.4 дэх хэсэг, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “хотын” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 14 дэх заалт буюу 19.6.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж тус тус өөрчилж, 2 дахь заалт буюу 21.2, 21.3 дахь хэсэг, 15 дахь заалт буюу 67.2.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 6 дахь заалт буюу 58.1.1 дэх заалтын “хот,” гэсний дараа “тосгон” гэж, 12 дахь заалт буюу 67.3 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “хот, тосгоны” гэж тус тус нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 6 гишүүн дэмжлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 56.3 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд ... энэ чинь яагаад 2 заалт орчихсон юм. 4 дүгээр зүйл дээр нь хураалгадаггүй юм уу. Зүйл зүйлээр хэлэлцэнэ гэсэн байхад “56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийн “нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт, улсын зэрэглэлтэй хотын Захирагч нь орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт” гэж,” гэсэн өгүүлбэр нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 7 гишүүн дэмжлээ.

Мөн Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 59.2 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “59.2 дахь

хэсгийн “нийслэл” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хот” гэж, “дүүргийн” гэснийг “дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, гэсэн өгүүлбэр нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ.

Мөн 3 дугаар зүйлийн 8 дахь заалт буюу 60.6 дахь хэсгийн “хот, улсын зэрэглэлтэй хотын хорооны” гэснийг “хотын” гэж, 9 дэх заалт буюу 61.3 дахь хэсгийн “Засаг дарга болон хот, тосгон, улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагч” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж, 12 дахь заалт буюу 67.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хот, — орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж тус тус өөрчилж, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг болон 13 дахь заалт буюу 8.5.1, 8.5.3 заалтыг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 7 дэмжлээ.

3 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

4 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт дахь “Засаг дарга болон Захирагчаас” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчаас” гэж, 4.1.27, 8.9.3, 59.2.4 дэх заалт, 23.8, 23.9, 25.8, 39.1 дэх хэсэг дэх “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “8.8 дахь хэсгийн” гэсний өмнө “8.5.1, 8.5.3 дахь заалтын “Хуралд” гэснийг “Хурал болон Зөвлөлд” гэж, гэж, “23.8, 23.9 дэх хэсгийн” гэсний өмнө “, 23.7.3 дахь заалт, 23.13 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн” гэснийг “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын” гэж, гэж, “25 дугаар зүйлийн” гэсний

өмнө “23.9.3 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, 24¹ дүгээр зүйлийн 24¹.1.1 дэх заалтын “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж, гэж, 59.8 дахь хэсэг дэх “тосгоны” гэсний өмнө “орон нутгийн зэрэглэлтэй хот,” гэж, “66 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн гарчгийн “Хурлын” гэснийг “Хурал, Зөвлөлийн” гэж, 65 дугаар зүйлийн гарчгийн “даргын” гэснийг “дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн” гэж, гэж, “66.1.3 дахь заалтын” гэсний өмнө “гарчгийн “даргын” гэснийг “дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн” гэж, гэж тус тус нэмж, 36.3 дахь хэсэг дэх “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 66.1.6 дахь заалт дахь “хотын хороо,” гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 7 дэмжлээ.

4 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

5 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

6 дугаар зүйл дээр асуулт, санал алга.

7 дугаар зүйл дээр асуулт, санал алга.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга.

2 дугаар зүйл дээр байхгүй байна.

3 дугаар зүйл дээр алга байна.

Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга.

2 дугаар зүйл дээр асуулт, санал алга.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль.

Төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулт алга.

2 дээр байхгүй.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль.

1 дээр асуулт, санал алга.

2 дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “22.5.1 дэх заалтын “аймаг” гэсний дараа “, хот”” гэснийг “22.5.1 дэх заалтын “сумын төв нь”, “суманд байнгын”, “сумын нутаг дэвсгэр”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө болон “албан татварыг аймаг,” гэсний дараа “хот,”” гэж өөрчилж, мөн зүйлийн “28.6 дахь хэсгийн” гэсний дараа

““татвар нь”, “жилд” гэсний дараах” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7.

2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн алга байна.

3 дээр асуулт саналтай гишүүн алга байна.

4 дээр асуулт саналтай гишүүн алга байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хууль санаачлан буцаах санал дэмжигдсэн.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжлээ.

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал алга байна.

2 дээр байхгүй байна.

3 дээр байна.

Төслийн 3 дугаар зүйлийн “Засаг даргын” гэсний өмнө ““хооронд”, “дээд шатны” гэсний өмнөх” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал

хураалт. Санал 7 гишүүнээр дэмжигдэж байна.

2 дугаар зүйл дээр саналгүй, асуултгүй.

3 дугаар зүйл дээр асуулт, саналгүй.

4 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

5 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

2 дээр байхгүй.

3 дээр алга байна.

4 дээр алга байна.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтын “Хурал” гэсний дараа “, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Энэ хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4, 35.1.5, 35.1.6, 35.1.7, 35.1.8, 35.1.9, 35.1.10, 35.1.11, 35.1.12, 35.1.13, 35.1.15, 35.1.16, 35.1.17, 35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.”” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулна. Дөхөж байна. Тун дөхөж байна. 11-ээс 8.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн гарчиг болон 35.1 дэх хэсгийн “Засаг даргаас” гэснийг “Засаг дарга, хотын Захирагчаас” гэж, 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтын “олгоход”, “сунгахад” гэсний дараах “нийслэлд” гэснийг “нийслэл, нийслэлийн харьяа улсын зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “1 000 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “500 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх “аймгийн төвийн суманд” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “500 000 төгрөг”, “200 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “300 000 төгрөг”, “100 000 төгрөг” гэсний өмнөх “бусад суманд” гэснийг “суманд” гэж тус тус өөрчилсүгэй.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8.

2 дугаар зүйл дээр санал, асуулт алга.

3 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна.

Улсын тэмдэгтийн тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн дугаарыг “40.8” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал дэмжье .7 гишүүн дэмжлээ. 1 дүгээр зүйл.

Төслийн 2 дугаар хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал дэмжье. Гаалийн татвар 8 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Ажлын хэсгийн саналыг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

1 дүгээр зүйл дээр санал байхгүй.

2 дугаар зүйл дээр.

Төслийн 2 дугаар зүйлийн “, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэсний дараа “хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэснийг “50 хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж,” гэсэн өгүүлбэр нэмэх. Ажлын хэсгийн саналыг

дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр санал, асуулт алга байна.

5 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
1 дүгээр зүйл дээр санал байхгүй.

2 дугаар зүйл дээр санал байхгүй.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төсөвт төвлөрүүлэх” гэсний өмнө “уг татварыг” гэж нэмэн, “харилцааг зохицуулна” гэснийг “харилцаанд үйлчилнэ” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ. 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

4 дүгээр зүйл дээр.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “тав тухтай амрах, зугаалах нөхцөлийг” гэснийг “байнгын болон улирлын үйл ажиллагаатай, үйлчлүүлэгчийн тав тухтай амрах нөхцөлийг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8 дэмжигдлээ.

5 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

6 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

7 дугаар зүйл дээр.

Төслийн 7 дугаар зүйлийн “түүний дагалдах хэрэгсэл” гэснийг “тэдгээрийн дагалдах хэрэгсэл” гэж, 7.2.5 дахь заалтын “угаалгын үйлчилгээ” гэснийг “угаалгын газрын үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 11-ээс 8.

8 дугаар зүйл дээр байхгүй байна.

9 дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй.

10 дугаар зүйл дээр.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “ногдох албан татварыг” гэснийг “ногдуулсан албан татварыг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр нь ... тийм байна шүү. Уучлаарай.

Одоо 11 дээр санал байхгүй.

Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль.

1 дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй.

2 дээр байхгүй.

3 дээр байхгүй.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох

тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 11, 13 дахь дэд заалтын “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр” гэснийг “Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 11-ээс 7 гишүүн дэмжлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 33 дахь дэд заалтын “Өвөрхангай аймгийн Арвайхээр сум” гэснийг “Өвөрхангай аймаг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Саяын санал уналаа шүү. Санал чинь 5 байна шүү дээ. 5 хүн байна шүү дээ. Үгүй ээ тэгээд гараа өргөөч. Дахиад санал хураалт явууллаа. Санал хураалт.

Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 52 дахь дэд заалтын “Дархан хот” гэснийг “Дархан-Уул аймаг” гэж өөрчлөх. Дэмжье. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. 8 хүн дэмжлээ.

4.Тогтоолын төслийн 5 дахь заалтын “чиг үүргийг” гэсний өмнө “зарим” гэж тохиолдол бүр нэмэх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. 7 хүн дэмжлээ.

5. Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмэх:

“6/Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зарим чиг үүргийг Шаргаморьт дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын зарим чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсгэй.

7/Нийслэлийн Багахангай дүүргийн чиг үүргийг Багахангай дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ.

6.Тогтоолын төслийн 9 дэх заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ.

Тогтоолын төслийн 10 дахь заалтын 1 дэх дэд заалтын “Нийслэл Улаанбаатар хотоос бусад” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ.

Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Би нэг анхнаасаа нэг санал хэлсэн. Учрал гишүүн. Тэнд сууж байгаа хүмүүс чинь бараг л хамгийн түрүүнд үүнээс сайхан санал алга л гээд байсан юм. Хархорин одоо байгаа Хархорин сумын төв Хархорин сум чинь шинэ Хархорум хотод ороогүй юм. Ороогүй байхгүй юу. Эд нар орсон гээд биччихсэн байгаа. Одоо Засгийн газрын тогтоолоор авсан тусгай хэрэгцээнд авсан газар дотор нь Хархорин сумын одоогийн төв огт ороогүй юм. Гэтэл нөгөө Хархорин сум нь өөрөө 15 мянган хүнтэй сум нь шинэ Хархорин хотдоо ч ороогүй, орон нутгийн зэрэглэлтэй хотдоо ч ороогүй үлдчихэж байгаа байхгүй юу. Тэгээд би энийг оруулах ёстой шүү гэж санал хэлсэн. Тэнд байсан хүмүүс л бараг л 2 гар, 2 хөлөө өргөсөн нөхдүүд л байсан юм. Тэгсэн чинь хаячихсан байгаа байхгүй юу. Том дотроо байхгүй юм байхгүй. Эд нар тэр том дотроо байгааг нь хараа ч үгүй байх л даа. Та нар Засгийн газрын тогтоолоо хараарай. Наад Хархорин сум чинь өөрөө ороогүй энэ том дотор чинь тэр.

Тэгэхээр Засгийн газрын тогтоолоор гаргасан тусгай хэрэгцээний газартай хотод чинь Хархорин сумын нутгаас орсон. Хашиат сумын нутгаас орсон. Өгий нуур сумын нутгаас орсон байхгүй юу. Яг одоо байгаа сумын төв чинь яг ингээд энэ тогтоолын дараа юу үлдчих вэ гэхээр сумаараа л үлдчихэж байгаа юм. Нөгөө орон нутгийн зэрэглэлтэй хот байхгүй болчхож байгаа байхгүй юу. 15 мянган хүнтэй газар чинь. Тэгээд би энийг хэлсэн байхгүй юу. Тэгээд энийг яах юм. Би зарчмын зөрүүтэй санал оруулах юм уу. Яах юм гэж асуух гээд байна.

Тэгвэл Ганболд гишүүн бид 2 үүгээр зарчмын зөрүүтэй санал орууллаа. Саяын “Хот байгуулах” тогтоол дээр орно. Энхболд гишүүн ээ, журмын хууль дээр орно. 2 юм дээр орох ёстой байхгүй юу. Томьёолол нь орон нутгийн зэрэглэлтэй хотоор Хархорин гэж орох юм. Одоо нэрээрээ.

Н.Энхболд: Ганболд гишүүн Тогтохсүрэн гишүүн гэсэн 2 гишүүн нэрээр. УИХ-ын гишүүн Тогтохсүрэн, Ганболд, Чинзориг нараас гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Түрүүн сая сая Тогтохсүрэн гишүүн шалтгааныг нь тайлбарласан үндэслэлээ хэлсэн. Ингээд Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дотор холбогдох заалтад нь оруулаад Хархорин хот гэж орон нутгийн зэрэглэлтэй хот гэж нэмэх саналыг дэмжье. Дэмжигдлээ.

Үүнтэй уялдаад “Хот байгуулах тухай” тогтоолд бас нэмэлт, өөрчлөлт орох ёстой. Саяын заалтаар, саяын утгаар энэ тогтоолд бас ийм заалтыг нэмье гэсэн саналыг дэмжье. Ингээд Тогтоол, Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Одоо Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан улсын их хуралд өргөн мэдүүлэх;

2/хот, тосгоны зөвлөл, захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11-ээс 7 гишүүн дэмжсэн байна.

Ингээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Жаргалмаа гишүүн танилцуулъя.

11.51 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Их Хурлын гишүүн Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай, Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Учралаар ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Одонтуяа, Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Энэ хугацаанд ажлын хэсэг нийт 2 удаа, дэд ажлын хэсэг нийт 9 удаа хуралдаж, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар нийт 10 зарчмын зөрүүтэй санал, найруулгын 8 санал, хамт өргөн мэдүүлсэн 4 хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй 6 саналын томъёоллын боловсрууллаа.

Хуулийн төсөлд тусгасан зарчмын гол өөрчлөлтүүдийг дурдвал Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чөлөөт

бүсэд тусгай дэглэм бүхий газар нутгийн хил зааг дотор олон улсын банк санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудаас бүрдсэн олон улсын санхүүгийн төв байгуулах бөгөөд түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор тусгалаа.

Мөн Хотын зөвлөлийн 9 гишүүний 6-г нь хотын оршин суугчдаас 4 жилийн хугацаатайгаар сонгохоор тусгалаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг батлагдсан тохиолдолд ердийн журмаар хэрэгжих бөгөөд хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолоор даалгасан болно.

Шинэ Зуунмод хотын төрийн захиргааны нэгдсэн цогцолборын мянган газрын эргэлтийн цэгүүдийн солбицлыг холбогдох журамд нийцүүлж газар зүйн солбицол болгон өөрчиллөө.

Мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналтай нийцүүлэн холбогдох саналыг боловсруулж хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засваруудыг хийсэн болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Сарангэрэл гишүүний микрофоныг өгье.

Д.Сарангэрэл: Надад нэг санал байгаа юм Энхболд дарга аа. 4 гишүүн хуулийн төсөл өргөн барьсан. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа юм. Тэгээд энэ хэлэлцүүлгийн завсраар бид нар тэр хуулийн төслийг оруулчих ийм саналыг гаргаж байгаа. Яагаад гэвэл энэ бас адууны соёл, ахуй уламжлалаа бас ард иргэддээ уламжлуулахад их чухал ач холбогдолтой. Тэгээд жороо морины уралдааныг Үндэсний их баяр наадамд бас заалтаар оруулах ийм хуулийн төслийг 4 гишүүн санаачилсан. Тэгээд үүнийг өнөөдрийн бас энэ хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгөхийг бол хүсэж байна.

Н.Энхболд: Энэ ерөөсөө ганцхан заалттай хууль байгаа нөхөд өө. Үүнийг нь яачихъя. Бас шалтгаан байна. Шинэ зуун модын урдуур оруулж хэлэлцэх горимын саналыг дэмжье гээд санал хураачихъя. Тийм гараар явж байна шүү дээ. Гараар явж байгаа. Гараа өргөөрэй. Оюунчимэг гишүүн яаж байгаа юм. 11-ээс 8. Горимын санал дэмжигдлээ.

Шинэ зуун модынхоо асуудлыг түр завсарлуулаад, Адьшаа нарын 4 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцээд өгчихье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Адьшаа гишүүн тавина. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Адьшаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьшаа: Байнгын хорооны гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд Найрамдах Улс мөн гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монголын Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус соёлын өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай 2022 оны 6 сарын 28-ны өдөр баталсан энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19-д Үндэсний баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно гэж заасан. Дээрх хуулийн заалттай холбогдуулан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж жороо морины уралдааны эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай болсон.

1996 оноос эхлэн жил бүрийн Улсын баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулсаар ирсэн бөгөөд жороо морины уралдааныг зохион байгуулах уяачид цол, чимэг олгох зохицуулалт нь тодорхойгүй байсан. Үндэсний их баяр наад наадмаар зохион байгуулах жороо морины уралдааны уяачид улс, аймаг, сумын цол чимгийг олгох нь эрт үеэс уламжлагдаж ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх наадамчин олны жороо морио дээдлэх, хүндлэх, хайрлах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд ач холбогдолтой гэж үзлээ. Адуу болгонд байдаггүй жороолох өвөрмөц явдал нь эрт үеэс морьтон монголчуудын ажигч гярхай нүдэнд өртөж, улмаар жороо мориог аянд унах нь бараг үгүй дээдлэн хайрлан, баяр наадам, баяр ёслолын, гоёлд унадаг унаа болон уламжилж ирсэн нь өнө эртний баялаг түүхтэй соёл юм.

Адууны сайварлах, жороолох явдлыг нүүдэлчин ахуй амьдралын ухаан туршилагаараа ялган ангилах, байгалийн үзэгдэл, амьтны хөдөлгөөний зүйрлэн усан тэлмэн жороо, хонин жороо, тэмээн жороо зэргээр нэрлэж, нэрлэгдсээр ирсэн өв соёл түүхэн уламжлалыг хойч үедээ өвлүүлэх түүгээн дэлгэрүүлэх зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо зөрчилдөхгүй бөгөөд жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачдад улс, аймаг, сумын чимэг цол олгох эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгасан.

Дээрх хуулийн зохицуулалт нь үндэсний морин уралдааны төрлийг нэмэгдүүлэх эрт үеэс уламжлагдаж ирсэн нь жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах хүсэл эрмэлзлийг нь нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн уяачдын наадмаар уламжлагдаж зохион байгуулж ирсэн жороо морь морины уралдааныг хөгжүүлэх нь Монголын өв соёл, уламжлал, зан заншлыг түүгээн дэлгэрүүлэхэд бодит хувь нэмэр оруулах болно. Хуулийн төсөлд дээрх зохицуулалтыг оруулснаар дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар эрт үеэс уламжилж ирсэн жороо морины өв соёлыг ирээдүй хойч үедээ түүгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Жороо морины уралдааныг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, уяачдын идэвх санаачилга, эрх зүйн байдал дээшилнэ. Үндэсний их баяр наадмын зохион байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Үндэсний их баяр наадмаар жороо морины уяачийн эрх, үүрэг

тодорхой болно. Жороо морины уяачийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, жороо морины уралдааныг зохион байгуулах эрх зүйн нөхцөл бүрдэнэ. Хууль хоорондын уялдаа холбоо сайжирна гэсэн ийм танилцуулгыг та бүгдэд хүргэж байна. Энийг бол Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Сарангэрэл, Одонгийн Цогтгэрэл бид 4 2023 оны 6 сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэ танилцуулгатай холбогдуулж та бүгдийн асуултад хариулахад бэлэн байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Адьшаа гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу. Ганболд гишүүн.

Г.Ганболд: Ер нь бол яах вэ болохгүй зүйл биш. Ер нь уламжлалаараа дээр үеэс энэ сумын наадамд бол жороо морь тойрдог л байсан. Тэгээд сүүлийн үед бол жороо морь эдэлж хэрэглэхээ болиод цөөрсөн л дөө. Зүгээр яах вэ эрийн 3 наадмын гэдэг маань жоохон тэлээд л байна. Шагай ороод л, одоо ингээд л жороо мориныхон ороод л сум, аймаг. Тэгээд сум болгонд цөөхөн морьтууд л байгаа л даа. Уралдаад л тэгээд л баахан цол чимэг юмнууд л болох гээд байна л даа. Энэ агуулгаараа нэг жаахан хавтгайрсан юм болох гээд байгаа юм шиг. Одоо тэгээд жороо морины уралдаан яваад ирэхээр нь мэдээж Ховд аймагт нэг хэсэг морьд байгаа. Гаднаас морьд орж ирнэ. Энэ Дундад Азиас, Хятадаас. Эрлийз гэж байх уу жороо моринд. Тэгээд эрлийз хурлийз гэдэг юм нь эхнээсээ ялгахгүй бол тэгээд л бас нэг хэрүүл. Гаднаас орж ирсэн морьд гээд. Энэ дээр яг ялгаж байгаа зүйл байгаа юм уу. Жороо морин дээр. Яг одоо Монгол адуу гээд ялгах ялгадаг юм уу. Эсвэл гаднаас ирж байгаа эрлийз морьдыг ер нь яаж ялгах вэ. Тэр дээр хууль санаачлагч яг ямар бодолтой байгаа юм. Энийг сонирхъё.

Н.Энхболд: Адьшаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяшаа: Ганболд гишүүний асуултад хариулъя. 1996 оноос л хойш энэ жороо мориныг төрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 13-ны өдөр уралдаж ирсэн түүхэн уламжлалтай. Эрлийз морины тухай бас асуудлыг Ганболд гишүүн хөндөж ярилаа. Энэ бол өнөөдөр Монголын уяачдын дунд Монголын төрийн наадмын дунд хамгийн их будилаан хутгаж байгаа, өнөөдөр эрх мэдэлтэй хүмүүс алдар цол горьдсон хүмүүсийн хооронд бий болж Монголын морины уралдаан, түүний дотор адууны соёлыг устгах хэмжээнд хүргэсэн ийм ноцтой асуудал байгаа. Монголын төр энийг шийдэж чадахгүй байгаа. 2022 онд Баяр наадмын тухай хуулийг шинэчилсэн найруулгын үеэр бид хэлэлцээд, энийг шийдэж чадаагүй шүү дээ. Өнөөдөр хүртэл Монгол Улсын Засгийн газарт адууны генетикийг тогтооё гэдэг ийм асуудлыг 2024 онд багтааж шийдье гэсэн, одоо хүртэл шийдээгүй л байгаа. Жороо морины тухайд бол өнөөдөр Монгол Улсын өнцөг булан бүрд жороо морь байна. Ганцхан Ховд аймагт байгаа юм биш. Өнөөдөр судалгаагаар бол Сэлэнгэ, Увс, Өвөрхангай түүнчлэн бол энэ говийн аймгуудад өнөөдөр тэр чигээрээ жороо морьтой хүмүүс байгаа.

Тийм учраас өнөөдөр ингээд бид нар энэ өргөн утгаараа өв соёл гэдгийг авч үзэх ёстой юм. 2014 оноос л эрлийз морь гэдэг юм баяр наадамд оруулж ирж ... байхгүй. Эрлийз байхгүй шүү дээ. Одоо бол ямар ч эрлийз байхгүй жороо морь дотор бол. Гаднаас морь оруулж ирэх нь бол уяачдын асуудал биш шүү дээ. Үүнийг чинь Хөдөө аж ахуйн яам л зөвшөөрөл өгч оруулдаг асуудал шүү дээ. Тэр Хөдөө аж ахуйн яам зөвшөөрлөө өгөөд оруулбал тэр асуудал нээлттэй байгаа л гэж ойлгож байгаа.

Н.Энхболд: Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт тавьж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн

байна уу. Алга байна. Санал хураана. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Машинаараа хураачихъя. Түрүүчийнхээ горимоор хураах юм байна гишүүд ээ, гараараа өргөнө шүү. Дахиад санал хураалт явъя. Гараа өргөж. 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

12.07 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаар танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч хийсэн. Одоо санал хураалтууд явуулна.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Одоо хэдүүлээ хурдан дуусгана.

Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна.

2 дээр байхгүй байна.

3 дээр байхгүй байна.

4 дээр байхгүй.

5 дээр байхгүй.

6 дээр байхгүй.

7 дээр асуулт, санал байхгүй.

8 дээр ажлын хэсгийн санал байгаа. Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр нь” гэснийг “эдэлбэр газар” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал. Ажлын хэсгийн гишүүн Учрал, Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Одонтуяа, Тэмүүлэн /цаашид

“ажлын хэсэг” гэнэ/. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт гараа өргөнө шүү. 8 гишүүн дэмжлээ. 8 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

9 дүгээр зүйл дээр санал байхгүй.

10 дугаар зүйл дээр санал байхгүй.

11 дээр санал, асуулт байхгүй.

12 дээр санал, асуулт байхгүй.

13 дугаар зүйл дээр.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “сонгон шалгаруулж, 4 жилийн хугацаагаар хотын Захирагч томилно” гэснийг “сонгоно” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал дэмжье. Гишүүд 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

14 дүгээр зүйл. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “(Цаашид ”Захирагчийн ажлын алба” гэх.)-” гэснийг хасах. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт 11-ээс 8 дэмжлээ.

15 дугаар зүйл дээр санал байхгүй.

16 дээр байхгүй.

17 дугаар зүйл дээр. Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,” гэсний дараа “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

17 дугаар зүйл дээр дахиад нэг санал байна.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь хэсгийн “академи” гэснийг “үндэсний хүрээлэн” гэж өөрчлөх.

Саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

Мөн Төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт доор дурдсан 17.3.6 дахь заалт нэмэх:

“17.3.6.олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа.” Ажлын хэсгийн санал дэмжье. 11-ээс 8 гишүүн дэмжлээ.

17-г хэлэлцэж дууслаа.

18 дугаар зүйл дээр.

Төсөлд доор дурдсан агуулгатай 18 дугаар зүйл нэмэх:

“18 дугаар зүйл.Олон улсын санхүүгийн төв

18.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан эдийн засгийн чөлөөт бүсэд тусгай дэглэм бүхий газар нутгийн хил зааг дотор олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн оролцогч байгууллагуудаас бүрдсэн олон улсын санхүүгийн төв байгуулна.

18.2.Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” Ажлын хэсгийн санал дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 11-ээс 8.

19 дээр алга байна.

20 дээр байхгүй.

21 дээр байхгүй.

22 дээр асуулт, санал байхгүй.

23 дээр ажлын хэсгийн санал байгаа.

Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “16.1.1-д зааснаас бусад” гэснийг “16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан”

гэж өөрчилж, “доор дурдсан салбарт” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 7 байна. Мөнхцэцэг гишүүн өргөөгүй. 11-ээс 7 гишүүн дэмжсэн.

Төслийн 24 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна.

25 дээр асуулт, санал байхгүй.

26 дээр асуулт, санал байхгүй.

27 дээр асуулт, санал байхгүй.

28 дээр асуулт, санал байхгүй.

Төслийн 29 дүгээр зүйлийг хасах ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 8.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засварыг хийх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 11-ээс 8 дэмжлээ.

Энэ хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо найруулгын санал.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх хэсгийн “бэлгэдэл тэмдэг” гэснийг “бэлгэ тэмдэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “9.5-д” гэснийг “9.6-д” гэж, 11 дүгээр зүйлийн “хороонд” гэснийг “хороололд”, “хороо” гэснийг “хороолол” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “13.4.4” гэснийг “13.4.5” гэж, “13.4.5” гэснийг “13.4.6” гэж, “13.4.6” гэснийг “13.4.7” гэж, “13.4.7” гэснийг “13.4.8” гэж, “13.4.8” гэснийг “13.4.9”, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж тус тус өөрчлөх.

Хамт униших юм уу.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Шинэ Зуунмод хот /цаашид “хот” гэх/”, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац /цаашид “корпорац” гэх/” гэсэнтэй нийцүүлж тохиолдол бүрд өөрчлөх.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Нийслэл” гэсний дараа “хот” гэж нэмэх гэсэн найруулгын саналуудыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8.

Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Шинэ Зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль байгаа юм уу.

1 дүгээр зүйл дээр байхгүй санал байхгүй.

2 дугаар зүйл санал байхгүй.

3 дугаар зүйл дээр хаана байна.

Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд Шинэ Зуунмод хотын хотын хөгжлийн корпорац нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1-д заасан олон улсын санхүүгийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангана.

2.Төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Захирагчийн чиг үүргийг хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч хэрэгжүүлэх бөгөөд түүнийг нийслэлийн Засаг даргын

санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. 11-ээс 8.

Одоохон дууслаа. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна.

2 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй.

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн “38.1.22” гэснийг “38.1.23” гэж, “40.8” гэснийг “40.9” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 7 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

3 дээр санал, асуулт байхгүй.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зөвлө зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

2 дээр байхгүй.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төсөл.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл.

Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье. 11-ээс 7. Та 2 дэмжиж байгаа юм уу 11-ээс 7.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоол хэлэлцэж дууслаа.

“Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийн үндэслэх хэсгийн “тус тус” гэсний өмнө “, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг” гэж нэмэх.

2.Тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршил” хүснэгтийн Төв аймгийн Сэргэлэн сумын “Шинэ Зуунмод /Төрийн захиргааны нэгдсэн цогцолбор/”-ын 1000 га газрын солбицлыг тэгш өнцөгтийн солбицлоор хийсэн байгааг газар зүйн солбицол болгон нийцүүлж доор дурдсанаар өөрчлөх гээд хүснэгт явж байгаа. Та бүхэнд тараасан байгаа. Энэ санал ажлын хэсгээс гарсан. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 11-ээс 7 дэмжлээ.

Ингээд “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулна.

12.22 цаг.

Ганболд нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн хууль байгаа. Ажлын хэсэгт баярлалаа. Хот, хөдөөгөөс ирж оролцсон, ялангуяа тосгодоос ирж оролцсон захирагч нартаа баярлалаа.

Ганболд нарын 6 гишүүнээс өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг ярина.

Хууль санаачлагчийн илтгэлийг Ганболд гишүүн танилцуулна.

Г.Ганболд: Байнгын хорооны байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг баталж, уг хууль нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид авч, иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаа хэлбэрийн төдий байна гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр орон нутгийн өдөр тутмын тулгамдсан асуудлаар ИТХ-ын байнга хуралдуулах шаардлага гарч тийм

боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл байдал үүсэж байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

ИТХ-ын зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж, уг хуулийн ИТХ-ын зөвлөл гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан.

Ингэснээр хурлын байгууллагын тасралтгүй идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх бөгөөд хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохыг хуулийн төсөлд тусгасан болно.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Засаг дарга, түүнийг томилох гэсэн 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалтад байгаа баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьсан нь амьдралд нийцэхгүй, дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгааг харгалзан хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой байхаар өөрчлөлт орууллаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 4 зүйлтэй.

Төслийн 1 дүгээр зүйлийн цахим болон технологийн бусад хэлбэрээр баг, хорооны ИНХ-ын хуралдаанд оролцсоныг

хурлын ирцэд оруулан тооцох, мөн 2 дугаар зүйлээр, аймгийн төв 20 мянгаас дээш хүн ам бүхий хот суурин газрын ИНХ-ын хуралдаанд 50 өрх тутмаас 1-ээс доошгүй иргэн хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцох зохицуулалтыг нэмж тусгасан. Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр баг, хорооны иргэдийн нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдааны даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгож, хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж ажиллах бөгөөд хуралдаан даргалагчид, баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх урамшуулал олгох, мөн ИТХ-ын зөвлөлд зарим эрх олгож, хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой иргэнийг сонгох зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн хурлын байгууллагын тасралтгүй идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм гэж хууль санаачлагчид үзсэн болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Ганболд гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуух гишүүн байна уу. Алга байна. Энэ ер нь нэлээн хүлээгдээд байсан хууль байгаа юм. Үг хэлэх гишүүн байна уу.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11-ээс 7.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд санал асуулга явуулж дууслаа. Дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Оюунчимэг гишүүн танилцуулчихъя.

12.27 цаг.

Одоо нэг тогтоол байгаа. Ганцхан тогтоол. Дараагийн асуудалдаа оръё.

“Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Би уншаад танилцуулчихъя гишүүд ээ. Чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.21 дэх заалт, 14.2 дахь заалтын хэсгийг үндэслэн тогтоох нь.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 5 сарын 16-ны өдөр шинэчлэн батлагдсан. Монгол Улсын Их Хуралд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах зорилгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаанд ди-парламент болон ди-өргөдөл цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт чиглэл болгосугай.

1/Монгол Улсын Их Хурлын ди-парламент болон ди-өргөдөл цахим системийг иргэд, олон нийтэд тайлбарлан танилцуулж сурталчлах ажлыг ИТХ-ын ажлын албаараа дамжуулан тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах.

2/Монгол Улсын Их Хурлын цахим хуудсаар дамжуулан хууль санаачлагчийн боловсруулж байгаа болон өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд иргэд саналаа

өгөх, Улсын Их Хурлаар тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрх зүйн орчин бүрдсэн талаар танилцуулж, сургалтууд зохион байгуулах,

Хоёр.Монгол Улсын Их Хурлын цахим системийн хэрэглээ ашиглалттай холбоотой асуудлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа өгч хамтран ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Д.Энхбат/-т даалгасугай.

Энэ тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээг Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлэхийг аймаг, нийслэл ирүүлж байхыг гэсэн дээр байх. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт үүрэг болгосугай.

Тухай бүр ирүүлж байхыг гэдэг юм уу ийм тогтоолын төсөл байгаа юм. Улсын Их Хурлын тогтоол гаргая гэж байгаад ер нь Байнгын хорооноосоо чиглэл болгоё гэсэн. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөе. Тогтохсүрэн гишүүн, Оюунчимэг гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Ганболд, Энхболд, Жаргалмаа, Мөнхцэцэг нарын гишүүд дэмжлээ. Тогтоол батлагдлаа.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудлаа дуусгалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

12.29 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ